

## Хөөрөгний тухай өгүүлэхүй

Докторант Х.Ариун-Эрдэнэ /МУ ДС/

Монгол угсаатны дунд он удаан жил уламжлагдан өнөө үед өргөн дэлгэр хэрэглэгдэж байгаа онцлог нэгэн эдлэл бол үнэт чулуун хөөрөг юм. Хөөрөг монгол овогтны харилцааны төдийгүй оюун санааны болон уран сэтгэлгээ, урлахуйн үнэт бүтээлийн нэг болно.

Монголчуудын харилцаанд хэрэглэж, мэнд амраа мэдэлцэж, танилцаж, өс саналгүй эв найртай явах цагаан сэтгэлээ илэрхийлж, хөөрөг зөрүүлэн мэндэлдэг уламжлалтай улс. Хувраг хүнд чойг, эгэл хүмүүнд хөөрөг хамгаас эрхэм бөлгөө.

Манай орноор аялан жуулчилж байсан гадаадын олон хүн монгол малчид ихэнхдээ ядуу амьдарч байсан атлаа туйлын гоёмсог эмээл, хазаар, гаанс, хөөрөг, алт, мөнгөн эдлэл хэрэглэж байсныг ХХ зууны эхэнд гайхан тэмдэглэж байжээ. Оросын эрдэмтэн И.К.Козлов /1899-1901/ Сайн ноён хан аймгийн Сайн ноён, Эрдэнэ Дайчин вангийн хошуу, Эрдэнэбандид хутагтын шавиар явж үзэж харсан тэмдэглэлдээ: "Энэ хошуу нутгийнхны өөр хоорондоо өрсөлддөг зүйл нь омголон жороо морь, эмээлийн тоноглол, хэрэгсэл, алт, мөнгөн эдлэл, эрдэнийн чулуун хөөрөг, гаанс бололтой"<sup>1</sup> гэж дурсан тэмдэглэсэн билээ.

Нүүдэлчин монгол эрчүүдийн хэрэглээ тухайн нийгмийнхээ соёл, хөгжил цэцэглэлтийг ямар нэгэн хэмжээгээр тодорхойлж иржээ. Хэн нэгэнд нь гайхуулах гэдэг утгаараа биш, хэрэглээ, үл хөдлөх хөрөнгө, эцэг өвгөдийн маань эдэлж хэрэглэж, үр хүүхэд бидэндээ үе дамжуулан үлдээсэн эдлэлийн нэг нь хөөрөг юм.

Хөөрөг барьж буй хэнээс ч гэсэн Та хөөрөгнийхөө талаар юу мэдэх вэ? Ямар чулуун хөөрөг вэ? гэх зэргээр асуун лавлахад мана, хаш болов уу гэхээс нэг их хэтэрдэггүй. Хөөрөгний үүсэл, хаана хэдийд үүссэн талаар бол бүр ч юм хэлдэггүй. Төв орон нутгийн сонин хэвлэлд, хөөрөгний үнэ нь төдөн сая төгрөг гэхээс илүү ямар нэгэн мэдээлэл байдаггүй билээ. "Хөөрөг", "Хөөрөг судлал" сонирхолыг минь татсаар музейн сан хөмрөгт хөл тавиулж, архив, номын сангийн шашдир бичиг зохиол, ном, судрын шарласан хуудсыг сөхөж эргүүлэхэд хүргэсэн билээ. Эрдэмтэн багш нар, урлаг, соёл, угсаатны зүйн судлаачид, шашин номын мяндаг тушаалтан, лам, хувраг, урлаг, спортын зүтгэлтэн, өвгөн буурлууд болон хөөрөг барьж буй хүн зонтой уулзан асууж, сураглан лавлаж, үзсэн дуулсан, сонссоноо тэмдэглэж, соронзон хальснаа буулган авч байлаа.

Энэ бүхнээ тунгаан нягтлаж энэхүү өгүүлэлийг уншигч олондоо хүргэхийг хичээв.

Хөөрөг хэзээ хаана, ямар улс гүрэнд, хэдийд үүссэн талаар түүх, урлаг, угсаатны зүйн болон урлаг судлалын талаас нь үнэлж дүгнэж бичсэн ном, товхимол, судалгааны бүтээл, өгүүлэл нийтлэл өнөө хир төдийлөн бичигдэж, хэвлэгдэгдээгүй байгаа болно.

Ямар нэгэн эдлэл хэрэгсэл, эд өлгийн зүйлс өөрийн үүсч гарах учир шалтгаан үр хөврөлтэй байх нь мэдээж хэрэг.

"Аливаа үндэстэн ард түмний соёлын түвшинг алт, мөнгө, төмөр зэрэг үнэт чулуун эрдэнэсийг өөрсдийн зэмсэг, чимэглэлд хир зэрэг хэрэглэж байснаар нь тодорхойлж болно" гэж К.Маркс хэлжээ. Иймд хөөрөгний үүслийн тухай олон домог яриа эдүгээр хүртэл яригдсаар ирсний заримаас сонирхуулъя.

"Нэгэн уран дархан хүн хамрын тамхи хийчих сав бүтээхээр зорьж элдвийг үзэж, энэ тэрийг сонирхон хэлбэр загвар, хийц донж нь ямархуу байхыг эрэгцүүлэн бодож явж л дээ. Гэрийнхээ зүүн хойморийн ханын шийрнээс уяатай нүцгэн хөвгүүнийг хараад түүний боов /бэлэг эрхтэн/ ямар нэгэн савтай төстэй болохыг ажиглажээ. Монголчуудын хөлд ороогүй нялх хүүхдийг гэрийнхээ зүүн хойд хойморт эцэг, эх хоёрын суудлын завсарт ханын шийрнээс уядаг байжээ"<sup>2</sup>. "Уяатай нүцгэн хөвгүүнийг харж, их бие нь бөөрөнхий, богинохон хүзүүтэй бяцхан толгойтой савыг бүтээвэй" гэж домогт өгүүлжээ.

<sup>1</sup> И.К.Козлов. "Монголия и Камчатка". Том. I-V, Том I "Петербург 1908.

<sup>2</sup> БНМАУ-ын Угсаатны зүй. I боть Халхын угсаатны зүй. Улаанбаатар. 1987.

Үүнээс чинагш Монголчууд бага насны хөвгүүнийг өхөөрдөхдөө "Тамхи татъя", "Тамхинаасаа өгөөч" /зарим газарт насмай үнэрлэе гэдэг/ гэхэд хүүхэд дуртай нь аргагүй боовныхоо хавиас гараараа чимхэн авч, тэр хүнд боовноосоо өгөхөд, тамхи гуйсан хүн "Аа, яасан сайхан үнэртэй юм бэ?" хэмээн үнэрлэсэн байдал үзүүлдэг заншилтай болсон аж.

"Ард түмний дунд хөвгүүдээ энхрийлэх яриа нь нэгэнт үнэн юм болохоор хэлбэр дүрсийн хувьд хүүхдийн боов, хөөрөг хоёрыг дүйцүүлэн үзсэн санааг зөвшөөрөхөөс аргагүй юм" гэж хэл шинжлэлийн ухааны доктор Д.Өлзийбаярын тэмдэглэн хэлсэнтэй санал нэг байна.

Өөр нэгэн домогт "Эрт балар цагт хүний мах иддэг махчин мангас хэмээх аймшигтай амьтан энэ дэлхий дээр байсан гэдэг. Хүмүүс махчин мангасгүйгээр энх тунх, амгалан амьдрахыг ихэд хүсдэг байжээ. Аймшигт амьтныг хүний гарт атгуулж номхруулж байх үүднээс хөөрөгний хоёр талын мөрөн дээр махчин мангас буюу сонин сайхан гэдэг хоёр амьтны дүрсийг дуурайлган сийлсэн гэдэг домог бий."<sup>3</sup>

Энэ дашрамд дурьдахад баруун Монголчуудыг мөртэй хөөрөг барьдаг байхад харин халхчууд мөртэй хөөрөг тэр болгон барьдаггүй байсан байна. Монгол ахуйн тусгал болох гүзээ, тулам, хөөрөг гурвыг хэлбэрийнх нь хувьд авч үзвэл адил төсгүй гэж хэлэхийн аргагүй. Үлээсэн гүзээ, хийлсэн тулмыг дуурайлган хөөрөгийг урласан хэмээн өөр нэгэн домогт ч өгүүлсэн байдаг.

Бас нэгэн домогт: "Эзэн Богд Чингис хаан Гуулин улсад дайлаар морджээ. Богд Чингис хаан дуг хийх зуураа нэгэн зүүд зүүдэлжээ. Их усан далайгаас урьд хожид үзэгдээгүй амьтан гарч ирээд:

-Монголчууд та нар их газартаа л эзэн байж, тэндээ эзэрхийлж бай. Эр биеийнхээ эсэн мэнд дээр, эмээлт мориныхоо амьд дээр эндээс үтэр түргэн буцахтун хэмээн хэлэхэд - Бид буцахгүй ертөнцийг эрхшээлдээ оруулж, бүгдийг дагуулна хэмээн Чингис хаан хашгиран сэrvээ" гэжээ. Чингис хаан зүүднийхээ тухай цэцэн мэргэддээ хэлж, тайлахыг шамдуулаад зургийг нь бургасны үзүүрээр газар дээр зурж, иймэрхүү л амьтан байсан даа гэжээ. Энэ нь тун сонин амьтны дүрс байсан бололтой. Үүнээс улбаалан хөөрөгний мөрөн дээр зээ бадийг урласан гэдэг.

Домог ярианы талаар Зөвлөлтийн монголч эрдэмтэн Н.К.Рерих "Хүн төрөлхтөн өчүүхэн бага ач холбогдолгүй юмны тухай домог зохиохгүй" гэж бичээд, домог үлгэрийг нарийн судалж уншвал уламжлалаа мэдэхэд их тустай гэж нэгэн судалгаандаа тэмдэглэжээ.

"Өвөр Монголын үндэсний урлахуйн зүйл" номонд Мин улсын үед /1368-1642/ анхлан тамхины хэрэгсэл "ХӨХҮҮР" үүссэн гэж тэмдэглэсэн бий. Хөхүүр хэмээхийг Я.Цэвэлийн зохиосон "Монгол хэлний товч тайлбар толь бичиг"-т: Хамрын тамхи агуулах чулуулаг буюу шил, шаазан мэтээр бяцхан сав гээд хашилтанд "ХӨӨРӨГ" гэж бичсэн байдаг. Өвөр болон баруун монголчууд хөхүүр, халх монголчууд хөөрөг гэж нэрлэнэ.

Мөн Я.Цэвэлийн дээрхи тольд: "Хамарт үнэрлэн хэрэглэх тамхи хийх савыг хөөрөг" гэсэн байхад "Монголын нэвтэрхий толь"-д үнэртэн хэрэглэх сав гэж тайлбарласан байдаг.

Түүхч, эрдэмтэн О.Пунцаг "Хөхүүр гэдэг үгийг эмэгтэй хүний хөхтэй холбон хөөрөгний толгойг хөхний товчтой адилтган эрхэмлэн үздэг байсан" гэсэн санааг гаргаж тайлбарласныг хойшид тодруулах нь зүйтэй юм. Я.Цэвэлийн тайлбар тольд "хөхөлт"-хөхөх үйлийн нэр, соролт, таталт гэсэн тайлбар хийсэн нь хамраар тамхийг сорох, татахтай уялдан тамхи хийсэн саваа хөхүүр гэж нэрлэдэг болсон ч байж магадгүй юм.

Хөөрөгний талаар өгүүлэхдээ тамхи, хамрын тамхины талаар дурьдахгүй өнгөрч боломгүй. Тамхийг хатуу хайрцагтай тамхи, улаан, шар, хар, навчин тамхи гэхээс гадна хамрын тамхи гэж нэрлэдэг. Манай эринээс 3000 жилийн тэртээ Ойрхи ба Дундад Дорнодод тамхи хэрэглэж байсан тухай архелогичид анх олж тэмдэглэжээ. XV зууны

<sup>3</sup> Л.Гомбожав.Хөөрөг.Улаанбаатар таймс. 1998.38-р дугаар.



төгсгөл буюу 1492 онд Испаний алдарт далайчин Кристофер Колумб Америк тивийг анх нээж, хүн төрөлхтөнд мөнхийн гавъяа байгуулсны зэрэгцээ, Америкийн ууган иргэд болох индиан хүмүүсийн хэрэглэж байсан тамхийг анх Европт аваачиж дэлгэрүүлжээ. 1556 онд Андре Тиве гэдэг гэлэн хүн тамхийг Бразилаас Францад сууж байсан Португалийн элчин сайд Жан Нико, 1559 онд толгой нь таллан өвддөг Францын хатан хаан Екатерина Медичид тамхи бэлэглэж, тамхины навчийг нунтаглаж, хамартаа татан сорохыг зөвлөж байжээ. Хамрын тамхинд элдэв сайхан үнэртэн хийснээр "Хатан хааны нунтаг" хэмээн хамрын тамхийг ихэд сурталчлан дэлгэрүүлсэн аж.

Хамрын тамхийг янз бүрийн сав, хайрцаг, лонхонд хийсэн байдаг бөгөөд түүнийг Мин улсын оршин тогтнолын сүүлч үед Европоос Хятад улсад дэлгэрч тархсан гэдэг. Хагарч, хэмхэрч болохуйц лонх хэлбэртэй сав хийдэг шил шаазан мэтийн материалыг өөрчилж шавар, шаазан, чулуу, металл эдлэлээр хийдэг болсон байна.

Харин хөрш зэргэлдээ Хятад улсаас Монголд тамхи дэлгэрчээ. Сэцэн хан аймгийн То ван /Б.Тогтохтөр/ 1834 онд "Хэбэй вангийн аж төрөхийг заасан сургаал болой" хэмээх бүтээлдээ Монголд тамхи татах явдал Европт Колумба тамхи авчрахаас ч өмнө Берингийн хоолойгоор Америкийн уугуул иргэдтэй харилцаж байх тэр цагт тамхи нэвтэрсэн байх гэсэн таамаглал байдаг" гэж тэмдэглэжээ.

Хамрын тамхийг агуулдаг сав хөөрөгний бүтэц, зохион байгуулалт, урлалын талаар зарим зүйлийг тэмдэглэж болох юм.

Өвөр Монголчууд "хөхүүр нь нэг шоо дөрвөлжин ямх хиртэй байдаг. Нарийнлаг сайхан нь янз бүрийн хэлбэртэй бөгөөд дээр нь элдэв зүйлийн гоё сайхан хээ угалзтай байвал сайн"<sup>4</sup> гэж үздэг ажээ. Хөөргийг хийсэн материалаар нь шилэн, шаазан, модон, хуван, шүрэн, гуулин, ясан, эврэн, чулуун, мөнгөн хөөрөг гэж ангилна. Хөөрөгний гол материал нь үнэт чулуу байдаг. Хаш, гартаам, чүнчигноров, болор, номин, пийсүү, мана, тана, анар, оюу, ундрэм зэрэг чулуугаар хийсэн хөөрөгийг үнэт чулуун хөөрөг гэнэ. Хөөргийг зориулалтаар нь эмэгтэй, эрэгтэй хүний, хүүхдийн, ямбаны, ширээний гэж ялгана. Эмэгтэй хүний барьдаг хөөргийг хавтагны гэж нэрлэдэг. Хавтагны хөөрөг нь жижигхэн, ямбаны болон ширээний хөөрөг нь том хэмжээтэй. Хөөргийг бүтцээр нь их бие, толгой, мөр, хүзүү, ёроол гэж хуваадаг. Хөөргөнд үзэмж донж оруулдаг зүйлийн нэг нь хөөрөгний толгой юм. Хөөрөгний толгойг болор, хув, ундрэм, мөнгө, пийсүү, оюу, номин, чүнчигноров, гартаам, шүрээр хийнэ. Хөөрөгний толгой өө сэвгүй өндөр, босоо хэлбэртэй байвал сайнд тооцогдоно. Алтаар нуухалж хүрээлсэн босоо толгойтой хөөргийг сайн хөөрөг гэдэг. Хөөрөгний их бие толгойн харьцаа нь 1/3, 2/3 гэсэн харьцаатай байвал зөв дүйцсэн хэмжээтэй хөөрөг гэдэг. Хамгийн том толгой нь дээр үеийн оросын тавтын мөнгөний хэмжээтэй байвал хөөрөгнөөсөө ч илүү үнэд хүрэх тохиолдол бий. Монголчууд хөөрөгнийхөө толгойг дээдэлж, ихэд хүндэтгэдэг нь аливаа зүйлийн тэргүүн толгой, их биеийг эрхэмлэн хүндэлдэгтэй холбоотой юм.

Хөөрөгний нуухыг алт, мөнгө, оюугаар хийнэ. Хөөрөгний халбагыг зэс, гууль, цайр, яс, эвэр, мод, мөнгөөр болон зааны соёогоор хийдэг. Зааны соёог алттай дүйцүүлж үнэлэх ч тохиолдол байдаг. Эрчүүд хөөргөө ихэд нандигнан хадгалдаг бөгөөд хөөргөө газар тавих, хөөргөн дээгүүрээ алхах, гишгэх, хагалахаас ихэд цээрлэнэ. Хөөрөгний үнэлэмж нь хөөрөгнийхөө чулууг өнгө донж, байгаль дээрх төрхийг хэрхэн олж, яаж хийсэн, хөөрөгний дотрыг яаж гаргасан, ухалт гүнзгий, хүзүүний нь диаметр хэд байхав, халбага ямар байх зэргээс ихээхэн шалтгаалдаг юм. Газар, газрын чулууны дархчуудын хийц өөр өөр байдаг. Монгол хөөрөг нь Хятад, Түвэдийн хөөрөгнөөс хийц, урлал, донжоор эрс ялгагдана.

Одоо Монгол улсын үндэсний түүхийн музей, Дүрслэх урлагийн музей болон иргэдийн гар дээр хаш, чүнчигноров, тана, мана, гартаам, болор, оюу, номин, анар, сувд, хув, шүр, пийсүү, ундрэм, мөнгө, сүйжин зэрэг үнэт чулуун хөөрөг хадгалагдаж байна. Түүнээс гадна зэс, гууль, цайр, хөнгөн цагаан, шил, шаазан, мод, үүфендөр хөөрөгнөөс

<sup>4</sup> Өвөр Монголын үндэсний урлалын зүйл. Хөх хот 1983 он 49-р тал

гадна ээдэмцэр, хиймэл материалаар хийсэн хөөрөг, тэр ч бүү хэл үхэр, ямааны эврээр хийсэн хөөрөг ч олноор байдаг билээ.

Хэлбэр дүрсийн хувьд хөөрөг нь нийтлэг хэлбэртэй байхаас гадна өвөрмөц содон хийцтэй хөөрөг цөөнгүй тохиолддог. Хоёр хөөргийг бөөрөөр нь нийлүүлж хийсэн ихэр хөөрөгний нэгэнд нь хатуу, нөгөөд нь зөөлөн тамхи хийж хослуулан татдаг ажээ.

Богц, дашмаг, борви хэлбэртэй хөөрөг ч байдаг юм. Бас хажуу бөөрөн дээр юм уу ёроолдоо эвхмэл үсэгтэй олон хөөрөг бий. Түүхч Ц.Хандсүрэн /эмэгтэй/ 1969 онд онд Ховд аймагт судалгааны ажлаар явж байхдаа Ням-Юндэн гэдэг хүнд хоёр бөөрөн дээрээ бичээстэй шүрэн толгойтой хаш хөөрөг байсныг үзэж сонирхжээ. Уг хөөрөгөн дээрхи бичээс үсгийг уншуулж тайлуулах үүднээс "Хэл зохиол судлал" /УБ.1969/ сэтгүүлд нийтлүүлсэн бөгөөд тэрхүү бичээсийг Кидан, Зүрчид, Тангад эвхмэл үсгийн аль нэг нь болов уу гэсэн таамаглал дэвшүүлж байжээ.<sup>5</sup> Өнөө хир ихэнхи хөөрөгөн дээрхи бичээс, эвхмэл үсгийг бүрэн тайлаагүй байгаагаас үзэхэд хөөрөг нилээд эрт үүссэн бололтой.

Нэрт эрдэмтэн Хөдөөгийн Пэрлээ агсан 1960-аад оны сүүлчээр бичсэн нэгэн бүтээлдээ "Монголчуудын гар дээр байгаа 12 хөөрөгөн (зохиогч 12 хөөргийг судлагдахуун болгож авч үзсэн бололтой.Х.А) дээрхи бичээс үсэг нь Кидан гүрний үед хэрэглэж байсан бйчиг"<sup>6</sup> гэж тэмдэглэсэн байдаг. Кидан, Монгол хоёр үндэстнийг гарал нэгтэй гэдэг. Кидан гүрэн 907-1125 онд Монгол нутаг дээр оршиж байсан улс бөгөөд чулуун урлал ихэд хөгжсөн тэр үйлдвэрлэлийг төрийн бодлогын хүрээнд авч үздэг улс байжээ.

Өнөө үед та бидний дунд дээр үеийн алдар хүндтэй хүмүүс, төр, нийгмийн зүтгэлтэн, хутагт хувилгаад, нам хуврагуудын эдэлж, хэрэглэж явсан дурсгалтай олон хөөргийг үе дамжин хэрэглэж иржээ. Тэдний заримыг дурьдвал:

Жа нам хэмээх хувилгаан Дамбийжанцангийн алтан нуух, шүрэн толгойтой зааны ясан халбагатай их гарын харлаг манан хөөрөг, VIII Богд Жавзандамба хутагтын чун гартаам хөөрөг, цогт эх оронч Манлайбаатар Д.Дамдинсүрэнгийн хас мэргэд эрдэнэ хөөрөг, Сайн ноён хан, ерөнхий сайд Т.Намнансүрэнгийн сангийн бойдаагийн тархи манан хөөрөг зэргийг дурьдаж болно. Түүнчлэн Монгол төрийн нэрт зүтгэлтэн, эрдэмтэн Жамсрангийн Цэвээний зэс хөөрөг, уг хөөрөгөн дээр нь Цэвээн Жамцарно гэдэг нэрийг уйгар бичгээр нэг нэгээр нь таслан бичсэн байдаг. Сэцэн хан аймгийн Илдэн жүн вангийн хошуу захирагч жүн ван Бат-Очирын Тогтохтөрийн /Олноо хэцүү То ван хэмээн алдаршсан / хэрэглэж явсан, хоёр бөөрөн дээрээ морь, бичний дүрстэй, нүдтэй шүрэн толгойтой халтар манан хөөрөг бидэнд уламжлагдан иржээ.

Дондогдулам хатан гартаам хөөрөг барьж байсан бөгөөд Сэцэн хан аймгийн Жонон ван Цогбадрахын /Хан Хэнтий уулын аймгийн Биндэрьяа уулын/ хошууны сурвалжит хатан Буянхишиг үүфэндэр хөөрөгтэй байжээ. Буянхишиг хатан уг хөөргийг өөрийн саальчин эмэгтэйд бэлэглэсэн гэдэг. Энэхүү хөөрөг нь 6 шүрэн шигтгээтэй цул мөнгөн толгойтой, хажуу талдаа эрдэнийн хар хасаар жаргалын найман морийг товойлгон сийлж нааж байрлуулсан аж. Энэ хөөрөг нь Халхад ховорхон ур чадвартай мөнгөний дарханы ур ухаанаар бүтжээ.

Түүнээс гадна Чингис хааны өв залгамжлах эрхтэй дөрвөн хатан болох Хангарьдын Дай Сэцэний охин Бөртэ, Дайр усуны охин Хулан, Татарын Их Черэн ноёны охид Есүн, Есүгэн нарыг цагаан шүрэн хөөрөг барьдаг байсан тухай сурвалж бичигт тэмдэглэсэн байдаг.

Хөөрөг хэрэглэхтэй холбогдон монголчуудын дунд өвөрмөц зан заншил, ёс дэг бий болжээ. Хөөрөг нь мэндлэх, уулзаж танилцахын эхлэл болж хэрэглэгддэг эдлэл болохоос гадна элч төлөөлөгчийн үүргийг ч гүйцэтгэж байсныг түүхэн баримтаас харж болно.

<sup>5</sup> Ц. Хандсүрэн. Нэгэн бичээстэй хөөрөг. ШУА-ийн Хэл зохиол судлал. Улаанбаатар 1969. 258-р тал

<sup>6</sup> Х.Пэрлээ. Кидан нар Монголчуудтай холбогдох нь УБ. 1959, 9-р тал



Хөөргийг бас бэлгэнд өгдөг уламжлалтай байжээ. Олноо өргөгдсөний наймдугаар оны сар шинийн нэгэнд VIII Богд Жавзандамба хаанаас Дээдийн амгалан айлтгасан ноёд, лам нарт шан буулгасан дансанд: Тэргүүн сайд, хичээнгүй туслагч Б.Цэрэндоржид: бүс-1, аяга-1, эрхи-1, хутга-1, Хөхүүр /хөөрөг/-1, хавтага-1 бэлэглэсэн тухай тэмдэглэжээ. Богд хаанаас өгсөн шан бэлгийн дотор хөөрөг бэлэглэсэн нь анхаарал татаж байна.<sup>6</sup>

Хөөргийг эмчилгээний зориулалтайгаар нилээд өргөн хэрэглэдэг аж. Тэр гуайн хөөрөгийг залж усанд хийж буцалгаад тий өвчинд увал сайн. Хүүхэдээ халуураад байхаад тэр гуайн хөөргийг суганд нь хавчуулчихсан чинь халуун нь буучихсан байсан шүү хэмээн ярилцдаг байлаа.

Хөөрөг бол зөвхөн гангарах, бэл бэлчинтэйгээ гайхуулах эдлэл байгаагүй. Үнэт чулуун хөөрөг нь Монголчуудын үл хөдлөх хөрөнгө, хадгаламж ч болдог.

Үнэтэй чулуун хөөрөг барьсан хэн боловч, биеэ зөв авч яваа харагддаг. Үнэтэй чулуун хөөрөгтэй яваа хэн ч гэсэн архи, дарс уулаа ч гэлээ хэр хэмжээндээ тааруулан уухаас бус "тасартлаа" уучихсан, гадаа гудамжинд унаж тусчихсан хүн тааралддаггүй, нэгэн бичигдээгүй ийм хууль үйлчилж байдгийг хэн хүнгүй санаж буй бизээ.

Монголчуудын хөөргөөр тамхилах ёстой холбож төрийн гурван тулгуурыг бэлгэдэж үзүүлсэн ч байдаг. Төрийн гурван тулгуур-тэнгэрийн хаан, хүний /өндөр төрийн/ хаан, лусын хаадыг төлөөлүүлэн /баруун гарын долоовор, дунд, ядам хуруудыг/ түшүүлж хөөргөөн бусдад өгч тамхилдаг. Хаан, Хатан, Их цэрэг гурвыг төрийн гурван тулгуур гэнэ.<sup>7</sup>

Эрдэмтэн, зохиолч Л.Түдэв гуай "Аман хууль" номондоо үхэгсдийн "сүнс гэтэлгэх" номыг оршуулганаас 3 хоногийн дотор лам залж, уншуулахдаа талийгаачийн хэрэглэж байсан гаанс, хөөрөг, эмээл хувцсыг нь ил тавьж, унадаг морийг өвч бүрэн эмээллэж уяж байгаад, мөнөөх сүнс гэтэлгэсэн ламд өргөл болгон өгдөг гэсэн бий.

Хөөрөгний нэгэн онцлог зүйл нь түүх архелогийн шинжилгээ, судалгааны олдсон олдвор, булш бунхан, хот балгасын туурь, сууринаас өдий төдий үнэтэй алт, мөнгө, хаш эрдэнийн эдлэл, эмээл хазаартай морь болон оршуулсан хүнийх нь эдэлж хэрэглэж байсан нум, саадаг, дөрөө, гутал хувцас, ээмэг бөгж, торго дурдан гарсан байдаг. Гэтэл үнэт чулуугаар урлаж хийсэн хөөрөг битгий хэл, хөөрөгний хэлтэрхий ч гарсан тухай мэдээ, мэдээлэл гадаад, дотоодын түүх, архелогийн тэмдэглэлд байдаггүй билээ. Энэ нь хөөрөгний онцлог шинж чанар, нууцлаг эд, хүмүүсийн хүндэтгэлтэй эдлэлийн нэг болохыг гэрчилнэ.

1930-1940-өөд оны үед хөөргийг хуучин нийгмийн үлдэгдэл, шашин шүтлэгтэй холбоотой мунхруулах эд зүйлс хэмээн ханддаг болсноос үнэ цэнэ, хүндэтгэлийн агуулгаа ихэд алдсан. Учир мэдэхгүй хүүхдүүдийн тоглоом ч болсон үе бий. Зарим үед томчууд хүртэл хөөргийг хагалж, чулууг нь цахиурын оронд хэрэглэдэг байсан тухай өвгөчүүл хуучилдаг. Сүүлийн жилүүдэд ямар хөөрөг ямар эрдэмтэй, хэн гэдэг сурвалжит хүнээс уламжлагдан ирсэн болохыг, ямар үнэ ханштай хөөрөг вэ? гэдгийг хүмүүс ихээхэн сонирхдог болсны зэрэгцээ хөөрөг цуглуулагчид ч олширчээ. 1968 онд Олон улсын Хятадын хөөрөг сонирхогчдын нийгэмлэг байгуулагдаж байжээ. Өнөөдөр дэлхий хөөрөгний гол цуглуулга нь АНУ, Хятад, Япон, Хонконг, Тайвань, Европын орнуудад гол төлөв хувийн хөөрөг цуглуулагчдын гарт байдаг байна. Ази, Европ, АНУ, Английн хэд хэдэн хотод хөөрөгний үзэсгэлэн, яармаг, худалдаа, үнэ хаялцуулах дуудлага худалдааг байнга зохиодог болсноос гадна хөөрөг цуглуулагчдад зориулсан тогтмол сэтгүүл, ном, товхимол ч нэлээд гарчээ.

Канадын Торонтогийн их сургуулийн профессор Виктор И Грэхэм, Хонконгийн их сургуулийн Хятадын урлаг судлалын доктор Кабо Цүнг болон хөөрөг судлаач Хью М Моссе нар хамтарч "Хятадын хөөрөгний урлал" ном зохиож, үзэсгэлэн гаргасан байна.

<sup>6</sup> МУТА.Ф-А-6, Т-1, ХН-402

<sup>7</sup> О.Пүрэв. Монгол бөөгийн шашин. Улаанбаатар. 1999.

Манай улсад ч хөөрөг сонирхогчид олширч, зургаагаас хорь орчим хөөрөгний цуглуулгатай хүмүүс ч байгаа болно. Харин монголын маань эд соёл, урлалын үнэт чулуун эдлэл болох хөөрөг Хятад, Тайвань, Хонконгийн хуучин эдлэл, үнэт чулуу цуглуулагчдын гараар дамжин хилийн цаана гарсаар байна. Заримдаа үнэ өртөггүй ч гарсаар байгаа нь харамсал төрүүлнэ.

Өнөө үед цагаан сараар, баяр ёслолын үеэр хэн хүний тамхилахаар хөөрөг барьсны хариуд барих юмгүй бол эвгүй байдаг гэж ярьдаг хүмүүс олон боллоо.

Хөөрөг, хөөрөг судлал судлаач эздээ хүлээсээр буй.

**"About the snuff bottles".  
The summary**

*By Kh. Ariun-Erdene*

The snuff bottles and its traditions are touched in this article. The rarest examples, most precious example. The origin, development and traditions are discussed in this article. The snuff bottle studies still remain the open issue.